

48. Цэгийн оронд нөхнө үү. Жижиг хэсгийн хэмжээ томрохын хэрээр диффузийн хурд . . .

- A. Өөрчлөгдөхгүй B. Ихэсдэг C. Буурдаг D. Тогтмол

49. Цэгийн оронд нөхнө үү. Жижиг хэсгийн масс ихсэхэд диффузийн хурд . . .

- A. Өөрчлөгдөхгүй B. Ихэсдэг C. Буурдаг D. Тогтмол

50. Хүн төрөлхтөн хийг хураан авч өргөн хэрэглэдэг. Хураан авч шахсан хийнүүдийн хэрэглээг зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу.

Шахсан хий		Хэрэглээ	
1	Азот	W	Баярын чимэглэл
2	Гели	X	Амьсгалын аппарат
3	Нүүрсхүчлийн хий	Y	Галын хор
4	Хүчилтөрөгч	Z	Автомашины дугуй

- A. 1Z,2X,3Y,4W B. 1Y,2W,3Z,4X C. 1Z,2W,3Y,4X D. 1Y,2Z,3X,4W

51. Дараах зургийг ажиглаад химийн нэгдлийн төлөвийн шилжилтийн өөрчлөлт болох **A, B, C** үзэгдлийн нэрийг зөв илэрхийлсэн хариултыг сонгоно уу.



- A. A-буцлах, B-конденсаци, C-хөлдөх B. A-хөлдөх, B-хайлах, C-конденсаци C. A-конденсаци, B-хайлах, C-хөлдөх D. A-хөлдөх, B-конденсаци

52. Шатамхай хий түлш агуулсан савыг нартай дулаан газар удаан тавих нь тэсэрч дэлбэрэх аюултай!!!



Шалтгааныг зөв тайлбарласан мэдээллийг сонгоно уу.


- I эзлэхүүн тогтмол битүү саванд буй хийн температурыг ихэсгэхэд молекулын хурд ихэсдэг.
 II хийн температур тогтмол үед хийн эзлэхүүнийг багасгахад савны даралт ихэсдэг.
 III хийн температурыг ихэсгэхэд хийн даралт тогтмол байвал молекулын хурд буурч эзлэхүүн тэлдэг.
 IV хийн температурыг нэмэгдүүлэхэд саван дах хийн даралт ихэсдэг.

- A. Зөвхөн I мэдээлэл B. Зөвхөн II мэдээлэл C. II ба III мэдээлэл D. I ба IV мэдээлэл

53. Багш хий дэх диффузыг дараах зургын дагуу туршжээ.



Туршилтын үр дүнг зөв илэрхийлж байгаа зургийг сонгоно уу.



A.

B.

C.

D.

54. Дараах диффузын үзэгдлүүдийг хурд нь ихсэх дарааллаар эрэмбэлсэн хэсгийг сонгоно уу.

- I. үнэртэй ус цацах II. этилийн спирт усанд уусах
III. зэсийн сульфат усанд уусгах

A. I < II < III

B. II < III < I

C. III < II < I

D. III < I < II

55. Өөр өөр нунтаглалттай ижил масстай зэсийн байвангийн диффузлэгдэх хурдыг судалжээ. Туршилтын үр дүнг харуулсан зургийг ажиглаад гадаргуугийн талб зөв жагсаасан хариултыг сонгоно уу.



A. 1 < 2 < 3

B. 2 < 1 < 3

C. 3 < 1 < 2

D. 3 < 2 < 1

56. Ижил масстай зэсийн байван бүхий 3 аяганд өөр өөр температуртай усыг ханыг дагуулан зөөлөн хийжээ. Сурагч зэсийн байван диффузлэгдэх хурд буур байрлуулбал:

2-р аяга > 3-р аяга > 1-р аяга

гэсэн үр дүнд хүрчээ. Хэрэв 3-р аяганд хийсэн усны температур 40°C байсан бол 1 ба 2-р аяганд хийсэн усны температурыг сонгоно уу.

	A	B	C	D
1-р аяга	40°C	10°C	60°C	10°C
2-р аяга	10°C	20°C	80°C	80°C


A.

B.

C.

D.

57. Диффузийг молекул кинетикийн онолоор тайлбарласан бүдүүвчийг ажиглана уу.



Диффузлэгдэх үеийг зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу.

	X	Y	Z
A	Эхлэхээс өмнө	Эхлэх үе	Дууссаны дараа
B	Дууссаны дараа	Эхлэхээс өмнө	Эхлэх үе
C	Эхлэх үе	Дууссаны дараа	Эхлэхээс өмнө
D	Дууссаны дараа	Эхлэх үе	Эхлэхээс өмнө


A.

B.

C.

D.

58. Сурагч уснаас бага температурт буцалдаг X шингэний буцлах цэгийг тодорхойлох даалгавар авчээ. Туршилтын дүнд дараах термометрийн заалт хүрээд X ш байна.



Зургийг ажиглаад X шингэний буцлах цэгийг сонгоно уу.

A. 125.5°C

B. 124.5°C

C. 95.5°C

D. 94.5°C

59. Усны уур хөрөх болон конденсацлах үзэгдлийг судалсан зургийг ажиглаад туршилт дуусах үе дэх усны температурыг сонгоно уу.




A. 140°C

B. 100°C

C. 60°C

D. 30°C

60. Усны уур хөрөх болон конденсацлах үзэгдлийг судалсан зургийг ажиглаад уур конденсацалж дуусах буюу ус хөрж эхлэх цэгийг сонгоно уу.




A.

B.

C.

D.

61. Усны төлөвийн шилжилтийг судалж буй зургуудыг ажиглана уу. Аль туршилтын явцад термометрийн заалт 12°C -ийг заах вэ?




A.

B.

C.

D.

62. Диаграммыг ажиглаад АБ ба ВГ хэрчмүүд бодисын төлөвийн ямар өөрчлөлтийг илэрхийлж байна вэ?



	АБ	ВГ
A	хөлдөх	конденсац
B	хайлах	буцлах
C	хайлах	конденсац
D	хөлдөх	буцлах

A.

B.

C.

D.

63. Монголчууд зуны улиралд гэрийн хаяавчаа сөхөж сэрүүцдэг энэ тохиолдолд гэрт халсан ба хөрсөн агаарын аль нь дээд талдаа байх вэ?

A. Халуун агаар

B. Хөрсөн агаар

C. Хоёулаа хамт холилдон бүлээн агаар болно

D. Агаар халахгүй

64. Хий хадгалсан баллон нь нартай дулаан газар удаан тавьсан үед дэлбэрэх аюултай байдаг үүнийг хийн шинж чанартай холбон зөв тайлбарласан хэсгийг ол

A. Хийн жижиг хэсгүүд халж илүү их хэмжээтэй болсон учраас

B. Хийн жижиг хэсгүүд хоорондоо хол хол зайтай, эмх замбраагүй хөдөлдөг учраас

C. Хийн жижиг хэсгүүд хоорондоо хол зайтай учраас шахагдах шинжтэй

D. Хийн жижиг хэсгүүдийг хурдсаж, сав доторх хий учраас

65. Усыг 35°C хүртэл халаахад төлөвийн шилжилт хийгддэггүйн шалтгаан юу вэ ?

66. Хатуу бодис тодорхой хэлбэр дүрстэй, эзлэхүүнтэй, урсахгүй, үл шахагдах шинжтэй байдгийн шалтгаан юу вэ ?

67. Шингэн бодис тодорхой хэлбэр дүрсгүй, урсамтгай шинжтэй байдгийн шалтгаан юу вэ ?

68. Хий бодис тодорхой хэлбэр дүрсгүй, шахагддаг, эзлэхүүн нь агуулж буй савныхаа хэмжээгээр өөрчлөгддөг шинжтэй байдгийн шалтгаан юу вэ ?

69. Хийн даралтад температур хэрхэн нөлөөлөх вэ ? 1 оноо Яагаад ? 2 оноо

70. Хийн даралтад эзлэхүүн хэрхэн нөлөөлөх вэ ? 1 оноо Яагаад ? 2 оноо


71. Хийн эзлэхүүнд температур хэрхэн нөлөөлөх вэ ? 1 оноо Яагаад ? 2 оноо

72. Диффузийн үзэгдлийг тайлбарлаж жишээ гаргана уу

73. Диффузийн хурдад нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлно уу!


74. Ёотонг хүйтэн болон халуун усанд уусгажээ? Аль нь түрүүлж уусах вэ? Шалтгааныг нь тайлбарлана уу

75. Зуны улиралд хүнсний бүтээгдэхүүн амархан мууддагийн шалтгаан юу вэ ?




А, В зураг дээрх жижиг хэсгийн загвар ямар төлөвийн шилжилтийг илэрхийлж байна вэ? Яагаад ?

77. А, В, С зураг дээрх жижиг хэсгийн загвар тус бүрд тохирох бодисыг нэрлэнэ үү



78. Хуурай мөс хий төлөвт шилжихэд ойрхон байсан хүн хэр зэрэг ноорох вэ? Яагаад?



А, Б, В, Г үсгээр тэмдэглэгдсэн төлвийн өөрчлөлтүүдийг нэрлэнэ үү.

80. Диффуз гэж юу вэ? Жишээгээр тайлбарлана уу?


81. Шингэн дэх диффуз хий дэх диффузээс удаан явагддаг шалтгааныг тайлбарлана уу?

82. Диффузийн хурд температураас хэрхэн хамаарах вэ? Шалтгааныг молекул кинетикийн онолоор тайлбарлана уу?


83. Диффузийн хурд хийн молекул массаас хэрхэн хамаарах вэ? Шалтгааныг молекул кинетикийн онолоор тайлбарлана уу?




Х, Y, Z үсгээр тэмдэглэгдсэн өөрчлөлтүүдийн аль нь эндотермийн процесс вэ? Хариултаа тайлбарлана уу?




Х, Y, Z үсгээр тэмдэглэгдсэн өөрчлөлтүүдийг нэрлэнэ үү?




A, B, C үсгээр тэмдэглэгдсэн бодисын төлвийг нэрлэж, жижиг хэсгүүдийн хөдөлгөөнийг молекул кинетикийн онолоор тайлбарлана уу?



Алинд нь калийн манганат (VII)-ын хөх ягаан өнгийн талст илүү хурдан тархах вэ? Яагаад?



X, Y, Z үсгээр тэмдэглэгдсэн өөрчлөлтүүдийн аль нь экзотермийн процесс вэ? Хариултаа тайлбарлана уу?




C үсгээр тэмдэглэгдсэн үзэгдлийг нэрлэж, тохирох 1 жишээ бичнэ үү?


90. Цайны аяганд ёотонг бүхлээр нь хийсэн зураг өгөгджээ. Цайнд ёотон жигд тархахын тулд ямар процесс болох ёстой вэ? Молекул кинетикийн онолоор тайлба



91. Ус руу хөх ягаан талстыг хийхэд үүсэх үр дүнг зургаар харуулжээ. Энэ туршилтаар ямар процесс явагдсан бэ? Молекул кинетикийн онолоор тайлбарлана уу?




92. Яндангаас гарч буй хийн молекулууд агаарт тархаж буй зураг өгөгджээ. Автомашины замын хажуугаар бага насны хүүхэд дагуулж явахдаа амны хаалт х. Үүний шалтгааныг тайлбарлана уу



Хийн даралт температураас хэрхэн хамаардаг вэ? Тайлбарлана уу?


94. Хийн даралт эзэлхүүнээс хэрхэн хамаарах вэ? Тайлбарлана уу?

95. Калийн перманганатыг тус бүр 100C, 250C, 900C температуртай усанд хийжээ.



1. Калийн перманганатыг усанд хийхэд юу болохыг тайлбарлана уу?
2. Энэ үзэгдлийг нэрлэнэ үү.

96. Калийн перманганатыг тус бүр 10⁰C, 25⁰C, 90⁰C температуртай усанд хийжээ.



10⁰C, 25⁰C, 90⁰C температуртай ус бүхий стакан тус бүрт калийн перманганат хэрхэн тархахыг зургаар дүрслэн харуулна уу?